



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 03 өдөр

Дугаар А/262

Арвайхээр сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 03/03 дугаар тогтоолоор батлагдсан хөтөлбөрийн 1.3.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, сагсан бөмбөгийн спортыг хөгжүүлэх зорилгоор “Арвайхээр лиг” аймгийн аварга шалгаруулах тэмцээний зардалд 10,000,000 (арван сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дээрх зардлыг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



И. ДОРЖСҮРЭН

6224 11 0540

D:My Doc. Zahiramj. Zasag darga